5.1. Сургалтын хөтөлбөрийн мэдээлэл харах

5.1. Сургалтын хөтөлбөрийн мэдээлэл харах

Сургалтын хөтөлбөрийн жагсаалтаас сургалтын хөтөлбөрийн нэр, код, төрөл, боловсролын төвшний мэдээллийг харах боломжтой.

Анхаарах нь:

- *Сургалтын хөтөлбөр нэмж үүсгэх шаардлага гарвал системийн тусламжийн утасруу холбогдох, и-мэйл илгээх (Жич: Сургалт эрхлэх тусгай зөвшөөрлийн мэдээллийг үндэслэн хөтөлбөр нэмнэ.)*



5.2. Сургалтын хөтөлбөрийн бүтцийн мэдээлэл харах

5.2. Сургалтын хөтөлбөрийн бүтцийн мэдээлэл харах

Сургалтын хөтөлбөрийн жагсаалтаас хөтөлбөрийн нэрийг сонгон дарснаар тухайн хөтөлбөрийн дэлгэрэнгүй мэдээлэл харах боломжтой.



БСМС-д батлагдсан тушаалын дагуу сургалтын төлөвлөгөөг бүртгэлжүүлж, хамаарах бүх сургалтын байгууллагын сургалтын төлөвлөгөөний мэдээлэлд үүсгэдэг. Жишээ нь: дунд боловсролын төлөвлөгөөг үүсгэхдээ суралцах анги түвшингийн буюу 6,7,8,9-р ангиудын хичээлүүдийг үүсгэдэг.



5.3. Сургалтын төлөвлөгөөний бүтцэд сонгон судлах төрлийн хичээл нэмэх

5.3. Сургалтын хөтөлбөрийн бүтцэд сонгон судлах төрлийн хичээл нэмэх

Систем ашиглан сургуулийн эрхээр “Төлөвлөгөөнд хичээл нэмэх” үед “Сонгон судлах” төрлийн хичээлийг удирдах боломжтой байна.



- **+Харьяалагдах элемент нэмэх** холбоосон дээр даран сонгон судлах төрлийн хичээлийг холбоно.
- **x** товчин дээр даран сонгон судлах төрлийн хичээлийн холбоосыг устгана

“Төлөвлөгөөнд хичээл нэмэх” цонхны талбарууд дараах байдлаар бөглөгдөх боломжтой байна. Үүнд:

• **Нөхцөл:**

Хичээлийн судлах төрлөөс хамааран автоматаар “Ба” эсхүл “Эсвэл” утга сонгогдон, харагдана. Гараас засварлах боломжгүй байна.

-Заавал хичээл нэмэх үед “Ба” /enrollment_category_id = Mandatory/

-Сонгон хичээл нэмэх үед “Эсвэл” /enrollment_category_id = Elective/.

• **Төрөл:**

Default утга нь “Хичээл” байна. Гараас засварлах боломжгүй байна.